



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 10,704,000.00 (арван сая долоон зуун дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа болон тогтоолд заасан байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг материал болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006839
37-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
2023.12.28 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэм жиж нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ (төгрөг)
1. Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги							
1	Автобус /64-61УНВ/	2011	ш	1	4,700,000.00	4,700,000.00	500,000.00
2	Фургон-уаз /04-01УНЭ/	2014	ш	1	2,200,000.00	2,200,000.00	300,000.00
	Дүн			2	6,900,000.00	6,900,000.00	800,000.00
2. 413 дугаар нээлттэй хаалттай хорих анги							
1	Мотоцикл /10-89СЭЗ/	2012	ш	1	1,350,000.00	1,350,000.00	100,000.00
	Дүн				1,350,000.00	1,350,000.00	100,000.00
3. 405-р хаалттай хорих анги							
	Дүн						
1	Мотоцикл	2017	ш	1	2,454,000.00	2,454,000.00	200,000.00
	Дүн				2,454,000.00	2,454,000.00	200,000.00
	Нийт дүн					10,704,000.00 (арван сая долоон зуун дөрвөн мянган)	1,100,000.00 (нэг сая нэг зуун мянган)